



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/682

Номгон

Нэгдсэн арга хэмжээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3, 5.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, 16.2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт мал хулгайлах болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал-Мах-2021” нэгдсэн арга хэмжээг 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Нэгдсэн арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, ажиллах хяналтын цэгийг хоёрдугаар, постод үүрэг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн хуваарийг гуравдугаар, шатахуун гаргах байгууллагуудын хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Нэгдсэн арга хэмжээнд шаардагдах 3.500.000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа) -т зөвшөөрсүгэй.

4.Нэгдсэн арга хэмжээний үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулж, танилцуулахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Сарангарав/-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601710591

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/68 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “МАЛ, МАХ-2021” АРГА
ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Зорилго: Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах, мал бүхий иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд, оршино.

Хариуцах газар: Аймаг сумдын Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар

Хугацаа: 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг дуустал.

Ажлын чиглэл: Сумдын нутаг дэвсгэрт байнгын болон хөдөлгөөнт пост ажиллуулан мал хулгайлах болон байгаль орчны журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын гоц халдвар өвчинтэй нутгаас мал, малын гаралтай түүхий эдийг тус аймгийн нутаг дэвсгэрт оруулахгүй нэвтрүүлэхгүй байх чиглэлээр ажиллана.


Арга хэмжээний явцад арга хэмжээний зорилго чиглэлийг ард иргэдэд сурталчлан, ажлын график хуваарь гарган, орон нутагт цаашид хийж хэрэгжүүлэх ажил, авах арга хэмжээний тухай санал хийсэн ажлын явц үр дүнгийн талаар 15 хоног тутам аймгийн Цагдаагийн газар нэгтгэн Хууль эрх зүйн хэлтэст ирүүлэх. (Цахимаар байж болно.)

Арга хэмжээнд идэвхтэй ажилласан алба хаагчид, иргэдийг урамшуулах асуудлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, хамтран ажилласан байгууллага хариуцан зохион байгуулна.

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 07 ний өдрийн 1682 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“МАЛ, МАХ” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР
БАЯНХОНГОР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ АЖИЛЛАХ
ПОСТУУДЫН ЗУРАГЛАЛ АЖИЛЛАХ ЦЭГ



1. Пост – Баруун хөтлийн замд
2. Пост- Арван мянгатын гол
3. Пост- Эрдэнэцогт сумын гарам Түйн голын гүүр.
4. Пост- Түйн голын гүүр

Жич: Аймгийн төвийн 4 постонд хөдөлгөөнтөөр үүрэг гүйцэтгэн хоногийн мэдээг постонд гарч ажилласан цагдаагийн алба хаагч илтгэх хуудсаар танилцуулна.

1.Баянхонгор сумын хэмжээнд Өлзийтийн пост, Баруун талын самбартай хөтөл, Антенаас ирэх замуудад төв шатахуун түгээх станцын орчим, Дуурсах багийн арын зам, Түйн голын Эрдэнэцогт сум явах гарам зэрэг газруудад

хөдөлгөөнт пост, арга хэмжээний хүрээнд Түйн голын гүүрний постод нэмэгдлээр Цагдаагийн алба хаагчийг ажиллуулах.

Постод Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас 1 албан хаагч, Хүнс хөдөө аж ахуйн газраас 1 албан хаагч, Цагдаагийн газраас 1 алба хаагч, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газраас ээлжээр өдөрт 1, Онцгой байдлын газраас 1 алба хаагч тус тус өглөө 09.00 цагаас гарч дараа өдрийн өглөөний 07.00 цаг хүртэл 1 автомашинтай гарч ажиллана.

2.Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн ахлах мөрдөгч 10 хоног тутам Өлзийт, Баян-Овоо, Галуут, Жинст, Бөмбөгөр, Заг, Жаргалант зэрэг сумдын малын хулгайн гэмт хэрэг үйлдэгддэг газруудад 4-5 хоногийн хугацаатай хөдөлгөөнтөөр явж ажиллана.

3.Автомашин техникийн бүрэн бүтэн байдал, шатахуун, шатах тослох материалыг Цагдаагийн газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар хариуцна.

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр
сарын 04-ний өдрийн 4/00 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

“МАЛ, МАХ-2021” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХҮРЭЭНД АЖИЛЛАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ХУВААРЬ

Д/Д	Хариуцах албан байгууллага	Гарч ажиллах өдөр
1	2	3
1	Цагдаагийн газар	XI/05
2	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XI/06
3	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/07
4	Сумын Засаг даргын Тамгын газар	XI/08
5	Онцгой байдлын газар	XI/09
6	Мэргэжлийн хяналтын газар	XI/10
7	Цагдаагийн газар	XI/11
8	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XI/12
9	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/13
10	Сумын Засаг даргын Тамгын газар	XI/14
11	Онцгой байдлын газар	XI/15
12	Мэргэжлийн хяналтын газар	XI/16
13	Цагдаагийн газар	XI/17
14	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XI/18
15	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/19
16	Сумын Засаг даргын Тамгын газар	XI/20
17	Онцгой байдлын газар	XI/21
18	Мэргэжлийн хяналтын газар	XI/22
19	Цагдаагийн газар	XI/23
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XI/24
21	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/25
22	Сумын Засаг даргын Тамгын газар	XI/26
23	Онцгой байдлын газар	XI/27
24	Мэргэжлийн хяналтын газар	XI/28
25	Цагдаагийн газар	XI/29
26	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XI/30
27	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/31
28	Сумын Засаг даргын Тамгын газар	XII/01
29	Онцгой байдлын газар	XII/02
30	Мэргэжлийн хяналтын газар	XII/03
31	Цагдаагийн газар	XII/04
32	Хүнс, хөдөө аж ахуйн газар	XII/05

Аймгийн Засаг даргын 2021 оны 14 дүгээр сарын 04-ний өдрийн 4682 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАЙГУУЛЛАГААС
ГАРГАХ ШАТАХУУНЫ ХУВААРЬ**

Баянхонгор сумын хэмжээнд пост ажиллах үеэр дараах хуваарийн дагуу байгууллагууд тухайн өдөрт зарцуулагдах 20 л шатахууныг хариуцана.

Д/Д	Байгууллагуудын нэрс	Шатахуун хүлээлгэн өгсөн огноо	Шатахууны хэмжээ
1	2	3	4
1	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар	XI/05	20 литр
2	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	XI/06	20 литр
3	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	XI/07	20 литр
4	Баянхонгор сумын ИТХ	XI/08	20 литр
5	Үйлдвэр Хөдөө аж ахуйн газар	XI/09	20 литр
6	Нийгмийн даатгалын хэлтэс	XI/10	20 литр
7	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	XI/11	20 литр
8	Төрийн банк	XI/12	20 литр
9	Эрүүл мэндийн газар	XI/13	20 литр
10	Зооноз	XI/14	20 литр
11	Ус цаг уур орчны шинжилгээний газар	XI/15	20 литр
12	Петровис ШТС	XI/16	20 литр
13	Мэдээлэл холбооны сүлжээ компани	XI/17	20 литр
14	Байгаль орчин аялал жуулчлалын газар	XI/18	20 литр
15	Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа	XI/19	20 литр
16	Аймгийн Шүүх	XI/20	20 литр
17	Аймгийн прокурорын газар	XI/21	20 литр
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	XI/22	20 литр
19	Биеийн тамир спортын газар	XI/23	20 литр
20	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	XI/24	20 литр
21	Татварын хэлтэс	XI/25	20 литр
22	Нисэх	XI/26	20 литр
23	Авто тээврийн газар	XI/27	20 литр
24	Монгол банк	XI/28	20 литр
25	Хаан банк	XI/29	20 литр
26	Эх булаг ШТС	XI/30	20 литр
27	Шунхлай ШТС	XI/31	20 литр

1	2	3	4
28	Хөрс ШТС	XII/01	20 литр
29	Жаст ойл ШТС	XII/02	20 литр
30	МТ ШТС	XII/03	20 литр
31	Шижир ойл ШТС	XII/04	20 литр
32	Цагдаагийн газар	XII/05	20 литр

_____оОо_____